

Зарим ББСБ-ын тусгай зөвшөөрөл  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.5 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.5 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хавсралтад дурдсан нэр бүхий Банк бус санхүүгийн байгууллагуудын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ж.Жадамбаа/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН БАНК  
БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

	Банк бус санхүүгийн байгууллагын нэрс	Гүйцэтгэх захирлын нэр	үйл ажиллагааны төрөл
1	“Грассленд ББСБ”ХХК	Жо Жае Хьюн	Зээл
2	“Дэлгэр экспресс ББСБ” ХХК	Б.Баяржаргал	зээл
3	“Сан кредит ББСБ” ХХК	Ц. Бат-Орших	зээл
4	“Өрнөх инвест ББСБ”ХХК	Х. Цэенхорлоо	зээл
5	“Чин ази ББСБ” ХХК	Б. Наранцэцэг	Зээл
6	“Дорнын тээвэр ББСБ” ХХК	П. Мөнхтөр	Зээл
7	“Од орчлон ББСБ” ХХК	М. Оюунбаатар	Зээл
8	“Дорнын хөтөч ББСБ”ХХК	Б. Оюунчимэг	Зээл
9	“Альфа кредит ББСБ” ХХК	Д. Намрсай	зээл